

Эрүүл мэндийн сайдын 2018 оны 02
дугаар сарын 12 -ны өдрийн дугаар
тушаалтын 3 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫГ ГЕПАТИТЫН В, С ВИРУСИЙН
ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ӨРТӨЛТИЙН ДАРААХ СЭРГИЙЛЭЛТ,
АЖЛЫН БАЙРНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ЗААВАР**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү зааврыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага, анагаах ухааны мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургууль, коллежид дагаж мөрдөнө.

1.2. Эрүүл мэндийн ажилтан нь эрхэлсэн ажил, мэргэжлээс хамааран гепатитын В, С вирусийн халдварт өртөх өндөр эрсдэлт бүлэгт хамаардаг. Үүнд:

- Цус, биологийн шингэнтэй шууд харьцаж ажилладаг бүх мэргэжлийн эмч /үүнд мэс засал, гэмтэл, эх барих, эмэгтэйчүүд, шүд, эмгэг судлал, лаборатори, түргэн тусламж, яаралтай тусламжийн эмч/, эмнэлгийн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, шүүхийн шинжилгээний шинжээч;
- Цус, цусан бүтээгдэхүүнтэй харьцан ажилладаг цусны төв, гемодиализийн төв/тасаг, эм, биобэлдмэлийн үйлдвэрийн ажилтан;
- Хурц үзүүртэй багаж хэрэгсэлд өртөх эрсдэл бүхий эрүүл мэндийн ажилтан, ариутгах, цэвэрлэх, угаах, хог хаягдал цуглуулах, зөөвөрлөх, устгах үүрэг гүйцэтгэдэг болон ариутгал, халдвартгүйтгэлийн тасаг/нэгжийн ажилтан, туслах ажилтан.

1.3. Эрүүл мэндийн байгууллага нь бүх ажилтан, албан хаагчдыг холбогдох журмын дагуу эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт хамруулах, ялангуяа шинээр ажилд томилогдсон ажилтныг гепатитын В, С вирусийн илрүүлэгт хамруулах, гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулах, дархлаажуулалтын дараа дархлал тогтсон эсэхийг тодорхойлох арга хэмжээг зохион байгуулна.

1.4. Эрүүл мэндийн байгууллага нь гепатитын В, С вирусийн илрүүлэг, гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулагдсан байдал, дархлал тогтоц болон вирусийн эсрэг эмчилгээ, эмчилгээний хяналт, давтан шинжилгээ зэрэг мэдээлэл бүхий нэгдсэн санг бурдуулж, мэдээллийн нууцыг хамгаалж ажиллана.

Хоёр. Илрүүлэг, оношилгоо

2.1. Шинээр ажилд орох зорилгоор эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдаж байгаа ажилтан, анагаах ухаан, сувилахуйн сургуульд элсэн орсон оюутан нь

Эмнэлэгт дадлагын хичээл хийхийн өмнө гепатитын В, С вирусийн илрүүлэг шинжилгээг заавал хийлгэсэн байна.

2.2. Эрүүл мэндийн ажилтны гепатитын В, С вирусийн илрүүлэг шинжилгээг “Гепатитын В, С вирусийн халдвартын илрүүлэг, лабораторийн оношилгоо хийх заавар”-ыг баримтлан гүйцэтгэнэ.

2.3. Гепатитын вирусийн халдвартай болох нь тогтоогдсон эрүүл мэндийн ажилтанд “В вируст гепатит (HBV), делта вируст гепатит (HDV)-ийн илрүүлэг, оношилгоо, эмчилгээний заавар”, “С вируст гепатит (HCV)-ийн илрүүлэг, оношилгоо, эмчилгээний заавар”-ын дагуу оношлуулж, эмчлүүлэхийг зөвлөнө.

2.4. Шинээр ажилд орох, анагаах ухаан, сувилахуйн сургуульд элсэн ороход хийлгэх урьдчилан сэргийлэх үзлэгийн илрүүлэг, дархлаажуулалтын дараах дархлал тогтоцыг тодорхойлох шинжилгээ болон гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулахтай холбоотой гарах зардлыг тухайн иргэн өөрөө хариуцна.

2.5. Гепатитын С вирусийн халдвартын эрсдэлд өртсөн тохиолдол бүрт эрүүл мэндийн ажилтан илрүүлэг шинжилгээнд давтан хамрагдана.

2.6. Хэрэв эрүүл мэндийн ажилтан гепатитын В вирусийн эсрэг дархлаатай нь батлагдсан бол цаашид шинжилгээг давтах шаардлагагүй, амьдралынхаа туршид дархлаатай болсон гэж үзнэ.

Гурав. Гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах

3.1. Гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунг хийлгэснийг нотлох бичиг баримтад тулгуурлан эрүүл мэндийн ажилтан, дадлагажигч эмч/оюутныг ажилд томилох, дадлагажигчаар ажиллах зөвшөөрлийг тухайн эрүүл мэндийн байгууллагын халдвартын сэргийлэлт, хяналтын баг олгоно.

3.2. Гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах эсэхийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Гепатитын В, С вирусийн халдвартын илрүүлэг, лабораторийн оношилгоо хийх заавар”-ын дагуу anti-HBs, anti-HBc маркерийг тодорхойлох шинжилгээ хийж, шийдвэрлэнэ.

3.3. Хэрэв anti-HBs, anti-HBc маркерын аль аль нь сөрөг гарсан бол гепатитын В вирусийн эсрэг вакцины гурван тунгаар дархлаажуулна. Вакцины эхний болон хоёр дахь тунгийн хооронд нэг сар, гурав дахь тун нь эхний тунг хийлгэснээс хойш 6 сарын зйтай байна.

3.4. Вакцины гурван тунг бүрэн хийснээс нэг сарын дараа дархлаажуулалтын дараах дархлал тогтцыг зөвхөн anti-HBs маркерийн тоон үзүүлэлтийг ашиглан тодорхойлно.

3.5. Хэрэв anti-HBs маркерийн тоон үзүүлэлт 10 mIU/мл-ээс бага бол гурван тунгаар давтан дархлаажуулах бөгөөд үүний дараа дархлал тогтцыг дахин тодорхойлохгүй, дархлаажуулалтыг давтах шаардлагагүй.

Дөрөв. Эрүүл мэндийн ажилтны гепатитын В, С вирусийн халдварт өртөлтийн дараах сэргийлэлт, ажлын байрны зохицуулалт

4.1. Ерөнхий зүйл

4.1.1. “Өртөлт” гэж арьс, салст зүү эсвэл бусад хурц үзүүртэй багаж хэрэгслээр гэмтэх, эсвэл цус болон биологийн шингэнээр цацагдах, бохирдох, арьсыг хазаж гэмтээх эрсдэлийг;

4.1.2. “Өртөлтийн дараах сэргийлэлт (ӨДС)” гэж цусаар дамжих халдварт өртсөн үед халдварт авах эрсдлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг хэлнэ.

4.1.3. Өртөлт, өртөлтийн дараах сэргийлэлтийн тохиолдлыг “Өртсөн тохиолдлын бүртгэл” Маягт 2-ын дагуу бүртгэж, өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг шуурхай авна.

4.1.4. Өртсөн ажилтныг эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх ажлын байрны давтан сургах арга хэмжээг халдварын сэргийлэлт, хяналтын баг тухай бүр зохион байгуулна.

4.1.5. Гепатитын В, С вирусийн идэвхтэй хэлбэрийн халдвартай нь оношлогдсон ажилтныг эмчилгээнд оруулах, вирусийн ачааллыг бууртал халдварт дамжих эрсдлээс шалтгаалан ажлын байрны зохицуулалт хийх асуудлыг халдварын сэргийлэлт, хяналтын баг шийдвэрлэнэ.

4.1.6. Гепатитын В, С вирусийн ачаалал өндөр байгаа эрүүл мэндийн ажилтан, өвчтөнд халдварт тархаахгүй байх халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээг зохион байгуулна.

4.2. Өртөлтийн дараах сэргийлэлт

4.2.1. Эрсдэлд өртсөн ажилтны үүрэг:

4.2.1.1. Эрсдэлд өртсөн даруй дараахь арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.

4.2.1.2. Хатгуулсан, зүссэн шархтай хэсэг, бохирдсон арьс, салстын цусыг шахаж, урсгал усаар, савандаж угаана.

4.2.1.3. Спирт эсвэл антисептик бодисоор шархыг цэвэрлэж, цус тогтоох цацлага, шархны наалт ашиглан боолт хийнэ.

4.2.1.4. Нүдэнд цус, биологийн шингэн цацагдаж орсон бол цэвэр ус, физиологийн уусмал эсвэл зориулалтын нүд угаагчийн аль нэгээр угаана.

4.2.1.5. Эрсдэлд өртсөн тухайгаа халдварын сэргийлэлт, хяналтын багт мэдээлнэ.

4.2.2. Халдварын сэргийлэлт, хяналтын багийн үүрэг:

4.2.2.1. Эрсдэлд өртсөн ажилтныг хурц үзүүр, ирмэгтэй багажид хатгагдсан тухай өртсөн тохиолдлын № 2 маягтын дагуу бүртгэнэ.

4.2.2.2. Эрсдэлд өртсөн ажилтны эрүүл мэнд, гэмтлийн байдал, халдвартын эрсдлийг үнэлэн, өртөлтийн дараах халдвараас сэргийлэх эмчилгээ, шинжилгээнд хамруулан, явцад нь хяналт тавина.

- Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ үргэлжлэх хугацаанд цус, эд эрхтэний донор болохгүй байхыг зөвлөнө.
- Өртсөн ажилтанд HBsAg, anti-HBc, anti-HBs, anti-HCV-ийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.
- Хэрэв үйлчлүүлэгч гепатитын В вирусийн халдвартай, эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан В вирусийн эсрэг дархлаагүй тохиолдолд /гепатитын В вирусийн эсрэг вакцин тариулаагүй, 3 удаагийн бүрэн тунг хийлгээгүй эсвэл вакцины 3 дахь тунг хийлгэнээс хойш 1 сарын дараах anti-HBs-ийн түвшин 10 mIU/ml-ээс бага/ эрсдэлд өртсөний дараах 48 цагийн дотор гепатитын В вирусийн өвөрмөц иммуноглобулин /HBIG/-ыг (0,06 мл/кг эсвэл 500 ОУН) булчинд тарьж, гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулна.
- Хэрэв үйлчлүүлэгч гепатитын В вирусийн халдвартай, эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан гепатитын В вирусийн эсрэг дархлаатай тохиолдолд /гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулгасан, anti-HBs-ийн түвшин 10 mIU/ml-ээс их/ дархлаажуулалт болон эмчилгээг хийхгүй.
- Хэрэв үйлчлүүлэгч халдваргүй, эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан гепатитын В вирусийн эсрэг дархлаагүй тохиолдолд HBIG иммуноглобулиныг тарьж, гепатитын В вирусийн эсрэг вакцины 3 тунгаар дархлаажуулна.
- Хэрэв үйлчлүүлэгч HBsAg, HBeAg эерэг, ХВВ-ийн ДНХ-ийн түвшин өндөр эсвэл эдгээр мэдээлэл тодорхойгүй, эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтан гепатитын В вирусийн эсрэг дархлаагүй тохиолдолд HBIG иммуноглобулиныг нэг сарын зйтай 2 удаа тарина.
- Хэрэв үйлчлүүлэгч гепатитын С вирусийн халдвартай тохиолдолд эрсдэлд өртсөн эрүүл мэндийн ажилтанд anti-HCV шинжилгээг хийнэ. 4 долоо хоногийн дараа ХСВ-РНХ-ийн ачааллыг тодорхойлох шинжилгээ хийнэ. Уг шинжилгээг 6 сарын дараа давтан хийнэ.

4.2.2.3. Эрүүл мэндийн ажилтныг гепатитын В вирусийн халдвартын эрсдэлд өртсөн гэж үнэлсэн бол HBsAg, anti-HBc маркерын давтан шинжилгээг 6 сарын дараа хийж, халдвар авсан эсэхийг тогтооно.

4.2.2.4. Хэрэв тухайн ажилтан халдвар авсан нь тогтоогдсон бол холбогдох зааврын дагуу оношилж, вирусийн эсрэг эмчилгээнд хамруулна.

4.3. Ажлын байрны зохицуулалт

4.3.1. Гепатитын В, С вирусийн архаг халдвартай эрүүл мэндийн ажилтныг вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд жил бүр хамруулна.

4.3.2. Хэрэв эрүүл мэндийн ажилтандаа гепатитын В, С вирусийн идэвхжил $\geq 10^4$ GE/ml бол хэвлэй, цээжний хөндий, зүрх, үе мөч, гэмтэл, мэдрэлийн мэс засал, төрөх, эрхтэн шилжүүлэн суулгах мэс ажилбарт оролцуулахыг хязгаарлах арга хэмжээ авна.

4.3.3. Эрүүл мэндийн ажилтандаа гепатитын В, С вирусийн халдвартай боловч өндөр эрсдэл бүхий ажилбар хийдэггүй эмнэлгийн ажилтан халдварт дамжуулах тархвар судлалын холбогдол байхгүй тохиолдолд байнгын сэргийлэлтийн арга хэмжээг дагаж мөрдөнө.

5. Эрүүл мэндийн ажилтны гепатитын В, С вирусийн халдвартын илрүүлэг, өртөлт, сэргийлэлтийг мэдээлэх

5.1. Эрүүл мэндийн ажилтны гепатитын В, С вирусийн илрүүлэг шинжилгээ, гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалт, дархлал тогтоц, өртөлтийн мэдээг гепатитын В, С вирусийн халдвартын илрүүлэг, өртөлт, сэргийлэлтийн бүртгэлийн №1 маягтын дагуу ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албанад дараа оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор албан ёсоор жил тутамд мэдээлнэ.

5.2. Өртөлтийн тохиолдол бүрийг цус болон биологийн шингэнд өртсөн тохиолдлын бүртгэлийн № 2 маягтын дагуу бүртгэн хариу арга хэмжээг авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвд мэдээлнэ.

**Гепатитын В, С вирусийн халдвартын илрүүлэг, сэргийлэлт,
өртөлтийн бүртгэлийн маягт**

Эрүүл мэндийн байгууллагын нэр

Бүртгэлийг илгээсэн огноо он сар өдөр

№	Үзүүлэлт	ЭМА-ы тоо
1	Тухайн эмнэлгийн нийт ажилтны тоо	
	Тухайн жилд шинээр ажилд орсон ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын В вирусийн халдвартай ЭМА-ы тоо	
2	Үүнээс гепатитын С вирусийн халдвартай ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын D вирусийн халдвартай ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын B, C вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын B, D вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын B, C, D вирусийн хавсарсан халдвартай ЭМА-ы тоо	
	Тухайн жилд гепатитын вирусийн илрүүлэг шинжилгээнд хамрагдсан нийт ЭМА-ы тоо	
3	Шинээр гепатитын B вирусийн халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
	Шинээр гепатитын C вирусийн халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
	Шинээр гепатитын D вирусийн халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
	Шинээр гепатитын B, C вирусийн хавсарсан халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
	Шинээр гепатитын B, D вирусийн хавсарсан халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
	Шинээр гепатитын B, C, D вирусийн хавсарсан халдвартай илэрсэн ЭМА-ы тоо	
4	Тухайн жилд гепатитын B вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулагдсан нийт ЭМА-ы тоо	
	Нэг дэх тунд хамрагдсан ЭМА-ы тоо	
	Хоёр дах тунд хамрагдсан ЭМА-ы тоо	
	Гурав дах тунд хамрагдсан ЭМА-ы тоо	
5	Тухайн жилд гепатитын B вирусийн эсрэг дархлал тогтцыг тодорхойлох шинжилгээнд хамрагдсан нийт ЭМА-ы тоо	
	anti-HBs 10 IU/мл-ээс бага гарсан ЭМА-ы тоо	
	anti-HBs 10 IU/мл-ээс дээш гарсан ЭМА-ы тоо	
6	Тухайн жилд цус болон биологийн шингэнд өртсөн ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын B вирусийн халдвараар халдвартагдсан ЭМА-ы тоо	
	Үүнээс гепатитын C вирусийн халдвараар халдвартагдсан ЭМА-ы тоо	
	Үүнээс цусаар дамжих бусад халдвараар халдвартагдсан ЭМА-ы тоо	
7	Тухайн жилд гепатитын B, C вирусийн идэвхжлийг тодорхойлсон нийт ЭМА-ы тоо	
	Вирусийн эсрэг эмчилгээнд орсон ЭМА-ы тоо (B, C)	
	Үүнээс гепатитын B, C вирусийн идэвхжил $\geq 10^4$ GE/ml гарсан ЭМА-ы тоо	
	Үүнээс ажлын байрны зохицуулалт хийгдсэн ЭМА-ы тоо	
Бүртгэл хөтөлсөн ХСХ-ын ажилтан: Нэр: Огноо: Гарын үсэг:		Хянасан ХСХ-ын багийн дарга: Нэр: Огноо: Гарын үсэг:

**Цус болон биологийн шингэнд
өртсөн тохиолдлын бүртгэлийн маягт**

1.Өртсөн хүний тухай мэдээлэл	<p>Нэр Овог Нас Хүйс: Эр <input type="checkbox"/> Эм <input type="checkbox"/></p>	<p>Эмнэлгийн ажилтны харьялагдах тасаг, нэгж</p> <p>Гепатитын В вирусийн эсрэг бүрэн дархлаажуулалтанд хамрагдсан уу? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/> Мэдэхгүй</p> <p>Хэрэв Тийм бол; Эхний тунг хийсэн он сар өдөр, серийн № 2 дахь тунг хийсэн он сар өдөр, серийн № 3 дахь тунг хийсэн он сар өдөр, серийн №</p>	
	<p>Эрсдэлд өртсөн огноо :он сар өдөрцагмин</p> <p>Өртөлт бүртгэгдсэн тасаг/нэгж Өөр хүн өртсөн эсэх? <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй</p> <p>Хийж байсан ажилбар болон өртөлтийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл. </p> <p>• Зүү: <input type="checkbox"/> Тариурын зүү, <input type="checkbox"/> Уламжлалт эмчилгээний зүү, <input type="checkbox"/> Бусад • Хурц үзүүртэй, иртэй бараж хэрэгсэл: <input type="checkbox"/> Мэс заслын хутга, <input type="checkbox"/> Оёдол тавих хэрэгсэл, <input type="checkbox"/> Төмөр утас, <input type="checkbox"/> Ампул, <input type="checkbox"/> Хуруу шил, <input type="checkbox"/> Бусад • Цус болон биологийн шингэн: <input type="checkbox"/> Цус, <input type="checkbox"/> Шээс, <input type="checkbox"/> Шархны шүүдэс, <input type="checkbox"/> Бусад</p>		
2.Эрсдэлд өртсөн тухай мэдээлэл	<p>Хувийн хамгаалах хувцас өмссөн эсэх <input type="checkbox"/> Халаад, <input type="checkbox"/> Бээлий, <input type="checkbox"/> Нүдний шил, <input type="checkbox"/> Амны хаалт, <input type="checkbox"/> Нүүрний хамгаалалт, <input type="checkbox"/> Бусад</p> <p>Гэмтсэн биөийн хэсэг <input type="checkbox"/> Долоовор хуруу, <input type="checkbox"/> Эрхий хуруу, <input type="checkbox"/> Гар/бугуй, <input type="checkbox"/> Гар/ тохой, <input type="checkbox"/> Нүүр /толгой/хүзүү, <input type="checkbox"/> Нүд, <input type="checkbox"/> Их бие (нүүрэн тал / нуруу тал) <input type="checkbox"/> Гуя/ өвдөг <input type="checkbox"/> Хөл/шагай, <input type="checkbox"/> Бусад</p> <p>Шархны байдал <input type="checkbox"/> гүн <input type="checkbox"/> дунд зэрэг <input type="checkbox"/> өнгөц</p>		
	3. Үйлчлүүлэгч өвчтөний тухай мэдээлэл	<p>Үйлчлүүлэгчийн өвчний түүхийн дугаар №:.....</p>	<p>Үйлчлүүлэгчийн овог нэр</p>

	<p><u>Үйлчлүүлэгч ямар нэгэн цусаар дамжих халдварт өвчнөөр өвчилсөн үү?</u></p> <p><u>Хэрэв тийм бол,</u></p> <p><input type="checkbox"/> ХВВ <input type="checkbox"/> ХСВ <input type="checkbox"/> Бусад</p> <p><input type="checkbox"/> ХДХВ <input type="checkbox"/> Тодорхойгүй</p>									
4. Авсан арга хэмжээ, хяналт	<p><u>Анхны тусlamж авсан талаар тэмдэглэнэ үү ?</u></p> <p>.....</p> <p><u>Өртөлтийн дараа Хепатит/ХДХВ-ийн илрүүлэг шинжилгээ хийсэн эсэх</u></p> <p>Тийм <input type="checkbox"/> <input type="checkbox"/></p> <p><u>Гепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулагдсан эсэх</u> <u>Эхний тунг хийсэн он сар өдөр, серийн №</u> <u>2 дахь тунг хийсэн..... он сар өдөр, серийн №</u> <u>3 дахь тунг хийсэн он сар өдөр, серийн №</u></p> <p><u>Дархлал тогтцын шинжилгээ хийлгэсэн эсэх</u> <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй</p> <p><u>Иммуноглобулин хийсэн эсэх</u> <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй</p> <p><u>Хэрэв тийм бол,</u> <u>Иммуноглобулин хийсэн он сар өдөр, серийн №</u> <u>Туншил Нэгж.....</u></p> <p><u>PBЭ эмчилгээ хийсэн эсэх</u> <input type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй</p> <p><u>Хэрэв тийм бол,</u> <u>PBЭ эмчилгээ хийсэн он сар өдөр</u></p>									
5.Баталгаажуулалт	<table border="1"> <tr> <td>Өртсэн ажилтан: Нэр:.....</td> <td>Халдварын сэргийлэлт хяналтын ажилтан: Нэр:.....</td> <td>Халдварын сэргийлэлт, хяналтын багийн дарга: Нэр:.....</td> </tr> <tr> <td>Огноо:</td> <td>Огноо:</td> <td>Огноо:</td> </tr> <tr> <td>Гарын үсэг:</td> <td>Гарын үсэг:</td> <td>Гарын үсэг:</td> </tr> </table>	Өртсэн ажилтан: Нэр:.....	Халдварын сэргийлэлт хяналтын ажилтан: Нэр:.....	Халдварын сэргийлэлт, хяналтын багийн дарга: Нэр:.....	Огноо:	Огноо:	Огноо:	Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг:
Өртсэн ажилтан: Нэр:.....	Халдварын сэргийлэлт хяналтын ажилтан: Нэр:.....	Халдварын сэргийлэлт, хяналтын багийн дарга: Нэр:.....								
Огноо:	Огноо:	Огноо:								
Гарын үсэг:	Гарын үсэг:	Гарын үсэг:								

6. Эрүүл мэндийн ажилтныг гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулах, дархлал тогтцын төсвийг тооцох

6.1. Ажилчдын гепатитын В вирусийн илрүүлэг, оношилгоо, дархлал тогтцын шинжилгээ, дархлаажуулалтад шаардлагатай санхүүжилтийг жил бүр байгууллагын төсөвт суулгаж шийдвэрлэнэ.

6.2. Гепатитын В вирусийн эсрэг дархлаажуулалт хийх, дархлал тогтцын төсвийг тооцоходоо дараах аргачлалыг ашиглана.

6.2.1. Дархлаажуулалт хийх ажилчдын тоог тооцох

$$A = \text{Бүх ажилчид} - \text{Дархлаажуулагдсан ажилчид} - \text{Вирус илэрч эмчилгээ хийгдэж байгаа ажилчид} + \text{Шинээр ирж буй ажилчдын дундаж тоо}$$

Төвчлол: $A = \text{Дархлаажуулалт хийх ажилчдын тоо}$

6.2.2. В вирусийн илрүүлэг шинжилгээний төсвийг бодох

$$B = A \times T_1$$

Төвчлол: $B = \text{Вирусийн илрүүлэг шинжилгээний шаардагдах төсөв}$

$A = \text{Дархлаажуулалт хийх ажилчдын тоо}$

$T_1 = B$ вирусийн оношлуурын үнэ

6.2.3. Anti-HBc, Anti-HBs шинжилгээний төсвийг тооцох

$$C = A \times 0.91 \times T_2 + A \times 0.91 \times T_3$$

Төвчлол: $C = \text{Anti-HBc, Anti-HBs шинжилгээнд шаардагдах төсөв}$

$A = \text{Дархлаажуулалт хийх ажилчдын тоо}$

$0.91 = B$ вирусийн тархалтын дундаж хувь

$T_2 = \text{Anti-HBc}$ шинжилгээний үнэ

$T_3 = \text{Anti-HBs}$ шинжилгээний үнэ

6.2.4. Anti-HBc, Anti-HBs (-) гарсан ажилчдыг дархлаажуулах төсвийг тооцох

$$D = A \times 0.91 \times 0.5 \times 3 \times T_4$$

Төвчлол: $D = \text{Anti-HBc, Anti-HBs сөрөг хариу гарсан ажилчдыг дархлаажуулах төсөв}$

$A = \text{Дархлаажуулалт хийх ажилчдын тоо}$

$0.91 = B$ вирусийн тархалтын дундаж хувь

$0.5 = \text{Anti-HBc, Anti-HBs сөрөг гарах дундаж магадлал}$

$3 = \text{Гурван удаагийн тун}$

$T_4 = B$ вирусийн эсрэг вакцин үнэ

6.2.5. Anti-HBs баталгаажуулах шинжилгээ хийх төсвийг тооцох

$$E = A \times 0.91 \times 0.5 \times T_3$$

Төвчлөл: $E = \text{Anti-HBs}$ баталгаажуулах шинжилгээ хийх төсөөв

A = Дархлаажуулалт хийх ажилчдын тоо

0.91 = В вирусийн тархалтын дундаж хувь

0.5 = Anti-HBc, Anti-HBs сөрөг гарах дундаж магадлал

T₃ = Anti-HBs шинжилгээний үнэ

6.2.6. Anti-HBs ≤ 10IU гарсан ажилчдын дахин дархлаажуулах төсвийг тооцох

$$F = A \times 0.91 \times 0.5 \times 0.3 \times 3 \times T_4$$

Төвчлөл: $F = \text{Anti-HBs} \leq 10IU$ гарсан ажилчдын дахин дархлаажуулах төсөөв

A = Дархлаажуулалт хийх ажилчдын тоо

0.91 = В вирусийн тархалтын дундаж хувь

0.5 = Anti-HBc, Anti-HBs сөрөг гарах дундаж магадлал

0.3 = Anti-HBs ≤ 10IU гарах дундаж магадлал

3 = Гурван удаагийн тун

T₄ = В вирусийн эсрэг вакцин үнэ

6.2.7. Нийт төсвийг тооцох

$$G = B + C + D + E + F$$

Төвчлөл: $G =$ Гөлөмийн В вирусийн эсрэг дархлаажуулах, дархлал тогтцын нийт төсөөв

B = Вирусийн илрүүлэг шинжилгээний шаардагдах төсөөв

C = Anti-HBc, Anti-HBs шинжилгээнд шаардагдах төсөөв

D = Anti-HBc, Anti-HBs сөрөг хариу гарсан ажилчдыг дархлаажуулах төсөөв

E = Anti-HBs баталгаажуулах шинжилгээ хийх төсөөв

F = Anti-HBs ≤ 10IU гарсан ажилчдыг дахин дархлаажуулах төсөөв

оOо